



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 599

Улаанбаатар хот

“Говь-Алтай АЗЗА” төрийн өмчит
хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Говь-Алтай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2020 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Ш.Тогтмолд даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД

0001255

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
589 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**"ГОВЬ-АЛТАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 оны гүйцэтгэл	2019 он		2020 оны төлөвлөгөө	Харьцуулалт	
				төлөвлөгөө	ХБГүйцэтгэл		2020төл/2019 ХБГ	зөрүү 2020 төл/2019 ХБГ
1	Нийт орлого	мян.төг	570,170.90	702,700.30	662,896.00	734,366.80	110.8	71,470.8
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	мян.төг	409,752.40	512,204.40	503,174.00	574,366.80	114.1	71,192.8
	Бусад	мян.төг	160,418.50	190,495.90	159,722.00	160,000.00	100.2	278.0
2	Нийт зардал	мян.төг	567,290.90	698,867.20	660,027.40	729,323.30	110.5	69,295.9
	Удирдлагын үйл ажиллагааны зардалд	мян.төг	132,083.90	165,327.40	154,212.40	186,665.60	121.0	32,453.2
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	2,880.00	3,833.10	2,868.60	5,043.50	175.8	2,174.9
4	Цэвэр ашиг/ алдагдал/	мян.төг	2,104.30	3,449.80	2,581.80	4,539.20	175.8	1,957.4
5	Орлогын татварт	мян.төг	775.60	383.30	286.80	504.30	175.8	217.5
	Төсвийн төлбөр, шимтгэл	мян.төг	116,049.30	139,874.50	120,097.20	149,563.50	124.5	29,466.3
	а. Орлогын татвар	мян.төг	302.70	383.50	862.40	504.30	58.5	-358.1
	б. НӨАТ	мян.төг	37,350.20	45,559.20	40,276.00	47,359.20	117.6	7,083.2
	в. НДШ	мян.төг	54,729.70	66,547.20	59,237.50	73,233.30	123.6	13,995.8
6	г. Хүн амын орлогын татвар	мян.төг	19,358.70	22,299.50	16,487.30	23,421.20	142.1	6,933.9
	д. Үл хөдлөх хөрөнгө	мян.төг	460.80	460.80	197.70	421.30	213.1	223.6
	е. Тээврийн хэрэгсэл	мян.төг	1,124.30	1,124.30	774.20	774.20	100.0	0.0
	ж. Бусад татвар	мян.төг	2,722.90	3,500.00	2,262.10	3,850.00	170.2	1,587.9
	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	452.50	517.70	315.60	680.90	215.7	365.3
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	30	32	31	32	103.0	1.0
8	Цалингийн сан	мян.төг	193,928.40	251,250.90	228,177.20	261,547.50	114.6	33,370.3
9	Нийт авлага	мян.төг	5,216.70	19,500.00	25,645.70	18,450.00	71.9	-7,195.7
10	Нийт өглөг	мян.төг	284,660.00	299,250.90	300,845.70	299,100.90	99.4	-1,744.8
11	Үүнээс: богино хугацаат	мян.төг	1,059.20	15,650.00	17,244.80	15,500.00	89.9	-1,744.8
12	Борлтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.99	0.99	0.99	0.99	100.0	0.00
13	Хөрөнгө оруулалт	мян.төг	26,603.70	55,476.70	47,519.40	70,000.00	147.3	22,480.6

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн
399 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**"ГОВЬ-АЛТАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Тухайн жилд худалдан авах хөрөнгийн нэр	хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Дүн
1	Суурин компьютер	ш	2	2,000.0	4,000.0
2	Асфальто бетон зүсэгч	ш	1	6,000.0	6,000.0
3	Ачааны автомашин /15-20 тонн даацтай өөрөө буулгагч/	ш	1	60,000.0	60,000.0
	Нийт дүн:				70,000.0